



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 10 дугаар цэцэрлэг 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/161/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

(Хотын нэр оруулах)

2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 99092469

Аудитын менежер:

Утас: 90077079

Аудитор:

Утас: 99032916

Цахим хаяг:

Э.Энхцэцэг

Цахим хаяг:

Э.Батчимэг

Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Дорноговь аймаг, Төрийн аудитын газар, Сайншанд сум, Орон нутгийн өмчийн 3-р байр

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	12

1 Аудитын гэрчилгээ

 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 2019.02.26 № 1-6/2013 таний _____ -ны № _____ -т	ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН ХҮҮХДИЙН 10 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Ц.НОМУУН ТАНАА
Аудитын гэрчилгээ	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 10 дугаар цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
Зөрчилгүй санал дүгнэлт	
<p>Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 10 дугаар цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
Санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 10 дугаар цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 10 дугаар цэцэрлэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 10 дугаар цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Ц.Номуунд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 10 дугаар цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 10 дугаар цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.18-наас 2019.02.20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Сайншанд сумын 10 дугаар цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.25-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 10 дугаар цэцэрлэгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Сайншанд сумын 10 дугаар цэцэрлэг нь СӨБ-ын үйлчилгээний шинэ арга хэлбэрийг дэмжих замаар хүүхэд бүрийг зохион байгуулалттай сургалт, хөгжүүлэх үйл ажиллагаанд тогтмол хамруулж, бага насны хүүхдийн хөгжүүлэх ажлын чанарыг сайжруулна гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 10 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн өмнөх насныханд анхан шатны боловсрол олгох

Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 10 дугаар цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 10 дугаар цэцэрлэгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Сайншанд сумын 10 дугаар цэцэрлэг санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох ХХК-ын "Acoluos" програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 10 дугаар цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 10 дугаар цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 0.2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь батлагдсан төсвийн дагуу зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж байгаатай холбоотой юм.

Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 10 дугаар цэцэрлэг 2018 оны Нийт зардал 647,140.00 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 1,294.28 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 9 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	243.10	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	2	243.10	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Илрүүлэлт:

Байгууллагын дотоод журамд заасны дагуу цалинтай чөлөө олгосон гэх боловч журамд заагаагүй үндэслэлээр 9-р сард туслах багш Б.Оюунтуяад 5 хоног цалинтай чөлөө 112,461.0 төгрөг, бүлгийн багш Н.Ариунгэрэлд 5 хоног цалинтай чөлөө 130,631.0 төгрөг тус тус бодож олгосон байна.

Эрсдэл:

Төсвийн тухай болон УСНББОУС зөрчих

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байгууллагын дотоод журам, хамтын гэрээг боловсронгуй болгож мөрдөж ажиллах

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 10 дугаар цэцэрлэгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой арга хэмжээнд зориулан 2018 онд 328,278.2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 325,277.17 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Сайншанд сумын 10 дугаар цэцэрлэгийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 10 дугаар цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 10 дугаар цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 10 дугаар цэцэрлэгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

- Дорноговь аймгийн Сайншанд сумын цэцэрлэгүүдийн захиргаа, ҮЭ-н гишүүдийн төлөөллийн 2017 оны 1-р сарын 18-ны өдрийн хэлэлцээрээр байгуулсан хамтын гэрээний 3.11-д илүү цагийн хөлсийг нөхөн амруулаагүй бол үндсэн цалинг 1,8 дахин нэмэгдүүлж олгохоор заасан боловч тус цэцэрлэг илүү цагийн хөлсийг 1,5 дахин нэмэгдүүлж бодсон байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Дорноговь аймгийн Сайншанд сумын цэцэрлэгүүдийн захиргаа , ҮЭ-н гишүүдийн төлөөллийн 2017 оны 1-р сарын 18-ны өдрийн хэлэлцээрээр байгуулсан хамтын гэрээний 3.11-д илүү цагийн хөлсийг нөхөн амруулаагүй бол үндсэн цалинг 1,8 дахин нэмэгдүүлж олгохоор заасан боловч тус цэцэрлэг илүү цагийн хөлсийг 1,5 дахин нэмэгдүүлж бодсон байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна 2017 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн хэлэлцээрээр байгуулсан хамтын гэрээ тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Цалингийн зардлыг буруу тооцоолсон байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Дорноговь аймгийн Сайншанд сумын цэцэрлэгүүдийн захиргаа , ҮЭ-н гишүүдийн төлөөллийн 2017 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн хэлэлцээрээр байгуулсан хамтын гэрээний 3.11-д илүү цагийн хөлсийг нөхөн амруулаагүй бол үндсэн цалинг 1,8 дахин нэмэгдүүлж олгохоор заасан байна. Цаашид хамтын гэрээний заалтыг мөрдөж ажиллах нь зүйтэй

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>26,765,327.73</u>	<u>26,489,506.13</u>
33	АВЛАГА	750,000.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	750,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	26,015,327.73	26,489,506.13
351	Түүхий эд материал	5,135,243.00	2,752,890.00
35110	Тусгай зориулалттай материал	5,135,243.00	2,679,090.00
35130	Эм боох материал	00.00	73,800.00
354	Хангамжийн материал	20,880,084.73	23,736,616.13
35410	Бичиг хэргийн материал	19,000.00	208,000.00
35420	Аж ахуйн материал	18,307,194.70	19,822,088.10
35440	Түлш, шатах тослох материал	00.00	110,000.00
35460	Хүнсний материал	2,553,890.03	3,596,528.03
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>997,267,352.39</u>	<u>995,670,411.33</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	997,267,352.39	995,670,411.33
392	Биет хөрөнгө	996,563,352.35	967,518,411.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	985,333,280.00	904,528,634.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	-36,293,374.00	00.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	33,142,009.50	45,204,515.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-12,754,241.93	-19,423,435.12
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,335,558.00	39,915,752.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,956,712.17	-12,876,919.34
39214	Бусад үндсэн хөрөнгө	785,750.00	9,573,397.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-340,491.63	-497,641.59
39217	Ном	311,574.58	1,094,107.90
393	Биет бус хөрөнгө	704,000.04	28,152,000.08
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-175,999.96	-263,999.92
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	27,536,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,024,032,680.12</u>	<u>1,022,159,917.46</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,761,503.11</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,761,503.11	00.00
413	Өглөг	2,761,503.11	00.00
4136	Бусад өглөг	118,250.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	118,250.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,021,271,177.01</u>	<u>1,022,159,917.46</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,021,271,177.01	1,022,159,917.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нуггийн сан	00.00	27,536,000.00
51101	Өмч: - төрийн	00.00	27,536,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,021,271,177.01	706,653,783.46
51210	Өмнөх үеийн үр дүн	1,021,271,177.01	1,021,175,177.01
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-314,521,393.55
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00.00	287,970,134.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,024,032,680.12</u>	<u>1,022,159,917.46</u>

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	203,574,100.00	332,618,333.32
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	2,689,933.32
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	2,689,933.32
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	2,689,933.32
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	2,689,933.32
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,000,000.00	4,650,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	202,574,100.00	325,278,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	4,650,200.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,850,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,000,000.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	212,269,328.09	342,891,003.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	212,269,328.09	342,891,003.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	212,219,328.09	338,939,274.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	124,497,171.00	191,360,015.00
210101	Үндсэн цалин	99,188,832.00	122,406,777.00
210102	Нэмэгдэл	18,523,785.00	55,295,391.00
210104	Урамшуулал	6,784,554.00	13,657,847.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,142,054.00	23,550,451.89
210201	Тэтгэврийн даатгал	14,142,054.00	18,864,498.89
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	937,191.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	1,171,488.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	234,298.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	2,342,976.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,915,839.00	38,940,645.00
210301	Гэрэл, цахилгаан	1,311,443.00	2,186,658.00
210302	Түлш, халаалт	17,351,268.00	30,364,700.00
210303	Цэвэр, бохир ус	3,253,128.00	6,389,287.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,843,280.00	9,616,585.60
210401	Бичиг хэрэг	382,000.00	1,678,846.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	216,000.00	250,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,245,280.00	3,094,000.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	4,593,739.60
2105	Нормативт зардал	29,192,774.27	47,103,192.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	41,000.00	00.00
210502	Хоол, хүнс	29,151,774.27	47,103,192.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	90,000.00	147,800.00
210604	Урсгал засвар	90,000.00	147,800.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	77,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	77,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	371,150.00	470,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	371,150.00	470,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,167,059.82	27,673,084.91
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	285,800.00	336,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,881,259.82	27,336,784.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,000.00	3,951,729.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,000.00	3,950,700.00

Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 10 дугаар цэцэрлэг 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	3,650,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	50,000.00	300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	1,029.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,029.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-8,695,228.09	-10,272,670.08
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	304,248,723.47
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	304,248,723.47
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-304,248,723.47
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-8,695,228.09	-314,521,393.55

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	203,574,100.00	329,928,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	203,574,100.00	329,928,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	202,574,100.00	325,278,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	4,650,200.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,850,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,000,000.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	191,638,303.00	316,868,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	191,638,303.00	316,868,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	191,588,303.00	312,916,671.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	123,445,219.00	190,322,200.00
210101	Үндсэн цалин	99,527,641.00	122,980,939.00
210102	Нэмэгдэл	17,133,024.00	53,700,241.00
210104	Урамшуулал	6,784,554.00	13,641,020.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,684,400.00	26,698,600.00
210201	Тэтгэврийн даатгал	13,684,400.00	24,944,801.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	350,760.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	438,474.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	87,715.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	876,850.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,915,839.00	38,940,645.00
210301	Гэрэл, цахилгаан	1,311,443.00	2,186,658.00
210302	Тулш, халаалт	17,351,268.00	30,364,700.00
210303	Цэвэр, бохир ус	3,253,128.00	6,389,287.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,760,195.00	4,687,096.00
210401	Бичиг хэрэг	310,050.00	1,218,396.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	110,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	216,000.00	495,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,234,145.00	2,863,400.00
2105	Нормативт зардал	29,782,350.00	50,319,630.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,000.00	98,800.00
210502	Хоол, хүнс	29,766,350.00	48,145,830.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	2,075,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	90,000.00	200,000.00
210604	Урсгал засвар	90,000.00	200,000.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	77,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	77,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	351,000.00	470,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	351,000.00	470,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	559,300.00	1,201,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	559,300.00	1,201,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,000.00	3,951,729.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,000.00	3,950,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	3,650,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	50,000.00	300,000.00

Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 10 дугаар цэцэрлэг 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	1,029.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,029.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>11,935,797.00</u>	<u>13,060,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>3,780,000.00</u>	<u>13,060,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>3,780,000.00</u>	<u>13,060,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	3,780,000.00	13,060,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,780,000.00	13,060,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-3,780,000.00</u>	<u>-13,060,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	8,155,797.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,155,797.00	00.00

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	1,055,746,710.00	1,055,746,710.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	1,055,746,710.00	1,055,746,710.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,617,717.37	-1,617,717.37
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	1,021,271,177.01	1,021,271,177.01
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	1,021,271,177.01	1,021,271,177.01
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-96,000.00	-96,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	1,021,175,177.01	1,021,175,177.01
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	287,970,134.00	00.00	287,970,134.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	27,536,000.00	00.00	-314,521,393.55	-286,985,393.55
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	27,536,000.00	287,970,134.00	706,653,783.46	1,022,159,917.46

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	325,278,200.00	325,277,171.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	325,278,200.00	325,277,171.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	321,327,500.00	321,326,471.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	186,884,400.00	186,884,400.00
210101	Үндсэн цалин	140,663,200.00	119,543,139.00
210102	Нэмэгдэл	33,792,200.00	53,700,241.00
210104	Урамшуулал	12,429,000.00	13,641,020.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,286,200.00	26,286,200.00
210201	Тэтгэврийн даатгал	17,523,900.00	24,669,901.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,058,200.00	323,260.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,884,700.00	404,074.00
210204	Ажилгүйдлийн даатгал	438,200.00	80,815.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,381,200.00	808,150.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,941,600.00	38,940,645.00
210301	Гэрэл, цахилгаан	2,187,600.00	2,186,658.00
210302	Түлш, халаалт	30,364,700.00	30,364,700.00
210303	Цэвэр, бохир ус	6,389,300.00	6,389,287.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,827,100.00	4,827,096.00
210401	Бичиг хэрэг	1,218,400.00	1,218,396.00
210402	Тээвэр, шатахуун	110,000.00	110,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	495,300.00	495,300.00
210404	Ном, хэвлэл	140,000.00	140,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,863,400.00	2,863,400.00
2105	Нормативт зардал	50,319,700.00	50,319,630.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	98,800.00	98,800.00
210502	Хоол, хүнс	48,145,900.00	48,145,830.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,075,000.00	2,075,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,320,000.00	12,320,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,800,000.00	10,800,000.00
210602	Тавилга	1,320,000.00	1,320,000.00
210604	Урсгал засвар	200,000.00	200,000.00
2107	Томилолт, зочны зардал	77,000.00	77,000.00
210702	Дотоод албан томилолт	77,000.00	77,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	470,500.00	470,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	470,500.00	470,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1201000.00	1201000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,201,000.00	1,201,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3950700.00	3950700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,950,700.00	3,950,700.00

Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 10 дугаар цэцэрлэг 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,650,700.00	3,650,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	325,278,200.00	325,278,200.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	325,278,200.00	325,278,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	325,278,200.00	325,278,200.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	25.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00